



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД

14251 Улаанбаатар хот,

Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11,

Утас: 6226-3168, Факс: (976-11) 31-23-15,

E-mail: info@mtd.gov.mn, http://www.mtd.gov.mn

2017. 06. 27 № 01/2937

танай _____-ны № _____-1

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ц.ДАВААСҮРЭН ТАНАА

Монгол Улсын Их Хурлын гишүүн Таны 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 08 тоот асуулгын хариуд холбогдох тайлбар, мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

Хувийг: Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт. ✓

Хавсралт: 5 хуудастай.


САЙД



Д.ГАНБАТ

08 528

2017 оны ... дугаар сарын ... өдрийн
01/2937 ... тоот албан бичгийн хавсралт



Монгол Улсын Их Хурлын гишүүн Ц.Дагасүрэнгийн
асуулгын хариу тайлбар, мэдээлэл

1. Аялал жуулчлалыг хөгжүүлэх төрийн бодлоготой уялдуулан агаарын болон авто замыг дунд хугацаанд хөгжүүлэхээр төлөвлөсөн ажил, Хөвсгөл нуурын сав газрыг тойрсон авто зам болон тухайн бүс нутгийг Тэрхийн цагаан нуурын аялал жуулчлалын бүстэй холбосон авто замын талаар;

Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д аялал жуулчлалын дэд бүтэц, үйлчилгээний чанарыг сайжруулах, бүсийн хэмжээнд олон улсын аялал жуулчлалын замналд нэгдэх, гадаадын жуулчдын тоог 2020 онд 1,0 саяд, 2025 онд 1,5 саяд хүргэх зорилт дэвшүүлсэн. Мөн Замын-Үүд, Хөшигийн хөндий, Алтанбулагт тээвэр логистикийн төв байгуулж, олон улсын болон улсын чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын уртыг 2020 он хүртэл 1600 км-ээр, 2025 он хүртэл 800 км-ээр тус тус нэмэгдүүлэхээр, гадаад, дотоод худалдааны тээврийн зардлыг бууруулах, хугацааг багасгах, аймаг болон томоохон сумдын нисэх буудлыг хөгжүүлэх, ерөнхий зориулалтын агаарын тээврийг хөгжүүлэх, үндэсний нисэхийн нөөц буудал байгуулах, агаарын тээвэрт чөлөөт өрсөлдөөнийг дэмжиж, Хөшигийн хөндийн нисэх буудлыг бүс нутгийн зангилаа төв болгон хөгжүүлэх зорилтыг тус тус тодорхойлсон билээ.

Агаарын тээврийн тухайд “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” болон Улсын Их хурлын 2013 оны 18 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”, Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг дунд хугацааны хөгжлийн баримт бичигт тусгасан, агаарын тээврийг өргөжүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх талаар дараах ажлуудыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Үүнд:

- “Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудал”-ын барилга байгууламж, тоног төхөөрөмжийг 2017 оны 1 дүгээр сард хүлээн авсан. Нисэх буудлыг 2018 оны 05 дугаар сараас бүрэн ашиглах бэлтгэл ажлыг хангаж байгаа бөгөөд энэ хүрээнд 2017 онд Улсын төсвийн 14,3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар аэродромын засвар үйлчилгээний барилга, ачаа шуудангийн терминал, захиргааны барилгыг барьж ашиглалтад оруулна;
- Говь-Алтай аймгийн “Алтай” нисэх буудлын хөөрч буух хатуу хучилттай зурвас, үерийн даланг барьж, ашиглалтад оруулсан, Завхан аймгийн “Доной” нисэх буудлын хөөрч буух хатуу хучилттай зурвас барих ажлыг 2017 онд дуусгахаар төлөвлөн ажиллаж байна;
- Шинэ нисэх буудлыг ашиглалтад оруулахад шаардлагатай агаарын хөлгийн ангарын барилга байгууламж барих, катерингийн барилга барих зэрэг ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхээр ажиллаж байна;
- Жижиг нисэх онгоц, нисдэг тэргээр нислэг үйлдэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, дэд бүтцийг хөгжүүлэх, найдвартай, хүртээмжтэй агаарын тээврийн сүлжээ бүрдүүлэх зорилтыг тодорхойлсон “Ерөнхий зориулалтын

нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр"-ийг боловсруулж, батлуулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Хөтөлбөрийг 2017-2022 онд хэрэгжүүлснээр ерөнхий зориулалтын нисэхийн эрх зүйн зохицуулалт сайжирч, нисэхийн салбарт бизнес эрхлэх таатай нөхцөл бүрдэж, хувийн хэвшил, хувь хүний оролцоо, хөрөнгө оруулалт болон ажлын байр нэмэгдэж агаарын тээврийн хүртээмж дээшилж, аялал жуулчлал, байгаль хамгаалал, хөдөө аж ахуй, газар тариалан, эмнэлгийн түргэн тусламжийн үйлчилгээ, агаарын геофизикийн судалгаа зэрэг бусад салбарын хөгжилд дэмжлэг болох нийгэм, эдийн засгийн ач холбогдолтой;

- Өмнөговь аймгийн Даланзадгад хотын нисэх буудлыг Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ICAO/-ын стандарт шаардлагыг хангасан 4D зэрэглэл бүхий Боинг 767, Боинг 747, Аэробус 340, 330 загварын агаарын хөлөг хүлээн авах хүчин чадалтай олон улсын нөөц нисэх буудал болгох судалгааны ажлыг хийх, уг ажилд шаардлагатай 300.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг гадаадын зээл, тусламжийн хүрээнд шийдвэрлүүлнэ;
- Дорнод, Ховд аймгийн нисэх буудлыг өргөтгөн шинэчилж, Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ICAO/-ын шаардлагыг хангасан, 4C зэрэглэл бүхий Боинг 737, Аэробус 320, загварын агаарын хөлөг хүлээн авах хүчин чадалтай болгох, уг ажилд шаардлагатай 90.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг гадаадын зээл, тусламжийн хүрээнд шийдвэрлүүлнэ.

Аялал жуулчлалын бүс Хөвсгөл аймгийн Мөрөн хотын чиглэлд хатуу хучилттай авто зам 2013 онд ашиглалтад орсноор агаарын тээврийн зорчигч урсгал эрс буурсан. Тус нисэх буудлаар 2016 онд 10,413 зорчигч үйлчлүүлсэн нь 2013 оныхоос (33811 зорчигч) 70%-иар буурчээ. 2017 оны зуны цагийн хуваарийн дагуу Мөрөн хотын нисэх буудалд 7 хоногийн 14 удаагийн буюу өдөр бүр 2 удаа нислэг гүйцэтгэж байна. Хатгал сумын нисэх буудал нь дунд оврын агаарын хөлөг хүлээн авах, цагт 50 зорчигчид үйлчлэх хүчин чадалтай бөгөөд жуулчин тээврийн нислэг хүлээн авахад бэлэн байгаа болно.

Хөвсгөл нуурын сав газрыг тойрсон авто замын тухайд Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Хатгал-Ханх чиглэлийн 179.7 км хатуу хучилттай авто зам барих, Хатгал-Жанхай-Тойлогт чиглэлийн 32.4 км хатуу хучилттай авто зам барих ажлыг 2019-2020 онд хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Уг зам баригдсанаар Улаанбаатар-Мөрөн-Хатгал-Ханх хилийн боомт чиглэл хатуу хучилттай авто замаар холбогдож, ОХУ-тай худалдаа, аялал жуулчлалыг дэмжих, бүс нутгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд чухал нөлөө үзүүлнэ.

Аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлоготой уялдуулан авто замын салбарт дунд хугацаанд дараах ажлуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Цэцэрлэг-Тосонцэнгэл чиглэлийн авто замаас Хөвсгөл аймгийн Жаргалант, Шинэ-Идэр чиглэлийн 95 км хатуу хучилттай авто зам, Өндөрхаан-Норовлин чиглэлийн 200 км хатуу хучилттай авто зам, Норовлин-Дадал чиглэлийн хатуу хучилттай авто зам барих ажлыг "Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр" болон төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад оруулахаар ажиллаж байна;
- Улаанбаатар хот-Олон улсын шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн 32.4 км хурдны авто замыг 2018 оны 07 дугаар сард барьж дуусгана;
- Засгийн газрын 2017 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн баталсан "Хөгжлийн зам хөтөлбөр"-т аялал жуулчлалын дараах бүс нутагт авто зам барьж, ашиглалтад оруулахаар тусгасан. Үүнд:

- Хэнтий аймагт: Чингис хот-Норовлин, Норовлин-Баян-Уул болон Норовлин-Дадал чиглэлийн хатуу хучилттай авто зам;
- Хөвсгөл аймагт: Хатгал-Ханх, Хатгал-Жанхай-Тойлогт, Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн замын төгсгөлөөс Мөрөн-Тариалан чиглэлийн замын төгсгөлийг холбох зам, Мөрөн -Тариат чиглэлийн хатуу хучилттай авто зам;
- Өвөрхангай, Баянхонгор аймагт: Хужирт-Бат-Өлзий-Улаанцутгалан-Найманнуур-Шаргалжуут чиглэлийн хатуу хучилттай авто зам;
- Сүхбаатар аймагт: Баруун-Урт-Дарьганга-Бичигт чиглэлийн хатуу хучилттай авто зам.

2. *Олон улсын болон дотоодын нислэгийн захиалгыг төлөвлөхөд хүндрэлтэй, найдваргүй, цуцалдаг, үнэ нь хэт өндөр, жуулчдын ихээхэн ачааллыг даадаггүй бага хэмжээгээр л явуулах боломжтой гэх мэт шүүмжлэлийг гадаадын жуулчны компаниуд тавьдаг. Энэ асуудлыг шийдвэрлэх талаар авч буй арга хэмжээний талаар*

Олон улсын нислэгийн захиалгыг дэлхийн түгээлтийн систем /GDS/ ашиглан, агаарын тээвэрлэгчийн борлуулалтын сүлжээгээр болон итгэмжлэгдсэн агентаар дамжуулан хийдэг. Нислэгийг жилд 2 удаа буюу Зуны /3 дугаар сарын сүүлийн Ням гарагаас 10 дугаар сарын сүүлийн Бямба гариг дуустал/ болон Өвлийн /10 дугаар сарын сүүлийн Ням гарагаас дараа оны 3 дугаар сарын сүүлийн Бямба гараг дуустал хугацаанд/ цагийн хуваарийн дагуу хэрэгжүүлж байна.

Монгол Улсын олон улсын нислэгийн зах зээлд дотоодын 3, гадаадын 5 агаарын тээвэрлэгч 7 орны 16 чиглэлд хуваарьт нислэг гүйцэтгэдэг бөгөөд 2016 онд олон улсын агаарын тээврээр 790,4 мянган зорчигч тээвэрлэсэн нь 2015 оныхоос (766.9 мянган зорчигч) 3% өссөн үзүүлэлттэй байна. Орон нутгийн нислэгээр 2016 онд 232.5 мянган зорчигч тээвэрлэсэн нь 2015 оныхоос (187,8 мянган зорчигч) 16%-иар өссөн үзүүлэлттэй байгаа ч уул уурхайн компаниудын аж ахуйн нислэгээр 127.3 мянган зорчигч буюу нийт зорчигчийн 55%-ийг тээвэрлэжээ.

Аймгийн төвүүдийг нийслэлтэй холбосон авто зам баригдсанаар, агаарын тээврийн тийзний үнэ өндөр, агаарын тээврийн компаниудын санхүүгийн чадавхитай холбоотойгоор Баянхонгор, Мөрөн, Даланзадгад, Алтай зэрэг чиглэлийн нислэг өвлийн улиралд зогссон. Зах зээлийн багтаамж бага, агаарын хөлгийн хүрэлцээ хангалтгүйгээс төлөвлөсөн хуваарьт нислэгээс гадна жуулчин тээврийн захиалгат нислэг гүйцэтгэх боломжгүй, мөн манай орны аялал жуулчлалын урсгал улирлын чанартай буюу зуны улиралд идэвхжиж, өвлийн улиралд буурдаг, орон нутгийн хуваарьт нислэг гүйцэтгэж буй 2 агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгийн хүчин чадал бага, хүрэлцээгүй зэрэг хүчин зүйлээс шалтгаалж нэг нислэгт олон тооны суудал урьдчилан нөөцлөх, хадгалах боломжгүй байдаг байна.

“Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг дунд хугацааны хөгжлийн баримт бичигт тусгасан, орон нутгийн болон олон улсын нислэгийн тоог нэмэгдүүлэх, өрсөлдөөнийг дэмжих замаар тус салбарт үнэ тарифыг бууруулах, агаарын тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд дараах ажлуудыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Үүнд:

- Иргэний агаарын хөлөг, түүний сэлбэгийг гаалийн татвараас чөлөөлөх зохицуулалтыг бүрдүүлэхээр Дэлхийн худалдааны байгууллагын “Иргэний

агаарын хөлөг худалдах тухай” олон талт хэлэлцээрт нэгдэх бэлтгэл ажлыг хангаж, УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хурлаар хэлэлцүүлэн дэмжүүлээд байна;

- Агаарын хөлгийн шатахууныг олон эх үүсвэрээс хангах боломжийг бүрдүүлэх, шатахууны үнийг болон орон нутгийн нислэгийн тарифыг бууруулах зорилгоор Цагааннуур хилийн боомтоор импортлох агаарын хөлгийн шатахууны гаалийн тарифыг “0” хувь хэмжээгээр тогтоох асуудлыг Гаалийн тарифын Зөвлөлөөр хэлэлцүүлэхээр хүргүүлж, шийдвэрлүүлэхээр ажиллаж байна;
 - “Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудал” ашиглалтад орохтой холбогдуулан олон улсын нислэгийн сүлжээг нэмэгдүүлэх, агаарын харилцааг өргөжүүлэх замаар нисэх буудлын ашиглалтыг сайжруулах хэрэгцээ шаардлагыг харгалзан агаарын харилцааны эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх зорилгоор Улаанбаатар хотноо 2017 оны 05 дугаар сарын 25-ны өдөр Агаарын харилцааны тухай Монгол Улс, БНЧУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг, ХБНГУ-ын Лейпциг хотноо 2017 оны 06 дугаар сарын 01-ний өдөр Агаарын харилцааны тухай Монгол Улс, Люксембургийн Их Вант Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг тус тус байгуулсан;
 - Мөн агаарын харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар Тайландын Вант Улсын Тээврийн яамтай уулзалт, хэлэлцээ хийж, нислэгийн багтаамж, давтамж, аялалын дугаар хуваан ашиглах зохицуулалт тохирч, 2017 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр Санамж бичиг байгуулсан;
 - Эдийн засгийн хүндрэлтэй байдлыг харгалзан дотоодын агаарын тээврийн үйлчилгээг алслагдсан бүс, орон нутгийн иргэдэд хүртээмжтэй болгох зорилгоор 2.1 тэрбум төгрөгийн татаасыг орон нутгийн нислэгт олгохоор төлөвлөсөн, хэрэгжүүлэх шатанд байна.
3. *Хатуу хучилттай 1 км авто замын стандарт, төсөвт өртөг өнөөдрийн байдлаар бүрэн тодорхойлогдсон эсэх, хэрхэн тодорхойлж шийдвэрлэж байгаа талаар. Тухайлбал Улсын төсвийн хөрөнгө, концессын гэрээ, гадны зээл, тусламжаар хэрэгжиж байгаа авто замын төсөвт өртөг өөр өөр байгааг хэрхэн зохицуулах, энэ талаарх судалгаа;*
- Улсын төсөв, гадаадын хөнгөлөлттэй зээл, тусламжаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хатуу хучилттай авто замын өртгийг тооцохдоо Зам, тээврийн сайдын 2016 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 186 дугаар тушаалаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын жишиг техникийн шаардлага”, “Зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох заавар”, Зам, тээврийн сайдын 2016 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 187 дугаар тушаалаар батлагдсан “Авто зам барилгын үйлдвэрлэлийн жишиг норм” 33БНБД 83-015-2016, “Авто зам барилгын ажлын төсвийн жишиг норм” 33БНБД 83-017-2016, “Төмөрбетон гүүр, хоолойн барилгын ажлын төсвийн жишиг норм” 33БНБД 83-018-2016, “Төмөр бетон гүүр, хоолойн барилгын үйлдвэрлэлийн ажлын жишиг норм” 33БНБД 83-016-2016, Сангийн, Зам тээврийн сайдын хамтарсан 2016 оны 152/10 тушаалаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажилд үнийн индекс тооцох техник, технологийн заавар” 33БНБД 81-014-2016 нормуудыг тус тус үндэслэн төсөв зохиодог.
 - Концессын гэрээгээр хэрэгжүүлэх хатуу хучилттай авто замын зардал, эдийн засгийн үр ашгийн тооцоог гаргахдаа Төрийн өмчийн хорооны 2010 оны 03

дугаар сарын 25-ны өдрийн 153 дугаар тогтоолоор батлагдсан "Концессын зүйлийн зардал, ашгийн тооцоо хийх түр аргачлал"-ын дагуу тооцож байна.

- Тухайн зам, гүүрийн барилгын ажилд хайгуул, зураг төслийн ажил хийгдсэний үндсэн дээр инженерийн нарийвчилсан зураг төслөөр ажлын тоо хэмжээг гаргаж, батлагдсан төсвийн норм үнэлгээг холбогдох шийдвэрийн дагуу барилгын ажлын төсөвт өртгийг тооцоолж гаргадаг. Авто замын төсөвт өртөг нь авто зам барьж буй газар нутгийн онцлог, хучилт, газрын бартаалаг, тээврийн зайнаас хамааран харилцан адилгүй байх тул 1 км авто замын жишиг төсөвт өртгийг бүрэн тодорхойлох боломжгүй юм.

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ